



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/384/НА-СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Ц.Хосжаргал  
Утас: 261628 Цахим хаяг: [khosjargalts@audit.gov.mn](mailto:khosjargalts@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Л.Нямтөмөр  
Утас: 261740 Цахим хаяг: [nyamtumurl@audit.gov.mn](mailto:nyamtumurl@audit.gov.mn)  
Аудитор: С.Бат-Эрдэнэ  
Утас: 261740 Цахим хаяг: [Bat-Erdenes@audit.gov.mn](mailto:Bat-Erdenes@audit.gov.mn)

Улаанбаатар хот  
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3.Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт .....	16
4.3 Албан шаардлага.....	16
4.4 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.02.24 № 07/314  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Б.НАСАНТОГТОХ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрчим хүчний яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрчим хүчний яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>37,928,265.27</b>	<b>90,673,464.56</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>755,589.27</b>	<b>13,580,775.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	755,589.27	13,462,775.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>0</b>	<b>118,000.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	0	118,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>37,172,676.00</b>	<b>77,092,689.56</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>37,172,676.00</b>	<b>77,092,689.56</b>
35410	Бичиг хэргийн материал	1,905,500.00	942,200.00
35420	Аж ахуйн материал	3,586,930.00	3,892,230.00
35430	Сэлбэг хэрэгсэл	603,000.00	603,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,048,981.00	3,136,532.00
35470	Бусад хангамжийн материал	30,028,265.00	68,518,727.56
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,703,690,211.52</b>	<b>5,705,164,000.16</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>5,703,690,211.52</b>	<b>5,705,164,000.16</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>5,509,991,473.24</b>	<b>5,513,409,640.16</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,064,939,664.10	3,064,939,664.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(284,171,050.30)	(369,687,531.22)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	372,230,774.18	412,790,774.18
39204	Хуримтлагдсан элэгдэл	(357,302,115.06)	(334,665,774.18)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	695,160,865.37	774,254,085.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	(456,998,142.76)	(473,881,247.11)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	425,007,688.30	414,836,592.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(276,493,423.92)	(299,019,207.62)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,562,371.72	5,465,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,753,358.39)	(5,430,916.66)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	2,323,808,200.00	2,323,808,200.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>193,698,738.28</b>	<b>191,754,360.00</b>
39301	Программ хангамж	3,333,220.00	0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,388,841.72)	0
39303	Бусад биет бус хөрөнгө	191,754,360.00	191,754,360.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,741,618,476.79</b>	<b>5,795,837,464.72</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,748,713.87</b>	<b>118,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,748,713.87</b>	<b>118,000.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>1,748,713.87</b>	<b>118,000.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,748,713.87	0
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>0</b>	<b>118,000.00</b>
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0	118,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,739,869,762.92</b>	<b>5,795,719,464.72</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>5,739,869,762.92</b>	<b>5,795,719,464.72</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,271,431,489.68	3,271,431,489.68
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,278,450,384.15</b>	<b>1,334,300,085.95</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	14,520,691.26	1,279,650,749.75
51220	Тайлант үеийн үр дүн	1,263,929,692.89	54,649,336.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,189,987,889.09	1,189,987,889.09
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>5,741,618,476.79</b>	<b>5,795,837,464.72</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>41,230,835,297.05</b>	<b>794,064,468,238.81</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,304,912,028.45</b>	<b>126,242,125.81</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,304,912,028.45</b>	<b>126,242,125.81</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,302,999,865.45</b>	<b>166,951.00</b>
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,302,999,865.45	166,951.00
120009	Бусад орлого	1,912,163.00	2,925,511.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	104,601,974.73
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	18,547,689.08
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>39,925,923,268.60</b>	<b>793,938,226,113.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>27,358,895,088.60</b>	<b>29,640,903,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	27,358,895,088.60	29,640,903,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>12,567,028,180.00</b>	<b>764,297,322,213.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,567,028,180.00	764,297,322,213.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>39,965,227,726.88</b>	<b>794,006,893,465.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>39,965,227,726.88</b>	<b>794,006,893,465.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,523,274,487.42</b>	<b>4,752,844,023.72</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,884,552,007.45</b>	<b>1,907,268,226.95</b>
210101	Үндсэн цалин	1,278,849,299.36	1,260,108,768.35
210102	Нэмэгдэл	551,236,708.09	582,598,621.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,466,000.00	64,560,837.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>264,034,062.47</b>	<b>252,871,506.77</b>
210201	Тэтгэврийн даатгал	177,534,364.43	175,414,406.86
210202	Тэтгэмжийн даатгал	21,624,899.45	19,573,877.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,299,999.20	15,531,420.99
210204	Ажилгүйдлийн даатгал	4,324,999.48	3,850,163.79
210205	Эрүүл мэндийн даатгал	43,249,799.91	38,501,637.98
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>74,744,572.21</b>	<b>81,106,858.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	51,136,600.00	60,620,373.00
210302	Түлш, халаалт	18,205,972.21	16,736,804.00
210303	Цэвэр, бохир ус	5,402,000.00	3,749,681.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>75,552,013.45</b>	<b>64,945,956.52</b>
210401	Бичиг хэрэг	13,364,550.00	10,480,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,996,801.00	5,920,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,373,031.45	27,666,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,050,000.00	122,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,969,431.00	15,343,875.00
210408	Бараа материал акталсны зардал	798,200.00	5,413,031.52
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>1,378,479.00</b>	<b>151,768.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,378,479.00	151,768.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,909,940.00</b>	<b>1,834,000.00</b>
210604	Урсгал засвар	2,909,940.00	1,834,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,313,300.00</b>	<b>1,410,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,313,300.00	1,410,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>30,888,924.00</b>	<b>2,223,216,154.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	2,198,655,350.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	3,043,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,689,246.00	949,086.00



210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,981,700.00	18,791,900.00
210807	Газрын төлбөр	1,828,478.00	526,488.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,389,500.00	1,249,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>185,901,188.84</b>	<b>220,039,553.48</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	185,901,188.84	220,039,553.48
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>37,060,986,362.00</b>	<b>788,921,080,742.69</b>
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>24,420,788,000.00</b>	<b>24,511,054,700.00</b>
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	24,420,788,000.00	24,511,054,700.00
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	<b>12,640,198,362.00</b>	<b>764,410,026,042.69</b>
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	12,640,198,362.00	764,410,026,042.69
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>380,966,877.46</b>	<b>332,968,698.59</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>3,495,036.00</b>	<b>1,694,240.00</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	3,495,036.00	1,694,240.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>63,912,745.60</b>	<b>40,038,786.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,985,720.00	22,638,786.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0	17,400,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,927,025.60	0
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>313,559,095.86</b>	<b>289,556,090.59</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	313,559,095.86	289,556,090.59
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0</b>	<b>1,679,582.00</b>
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	0	1,679,582.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,265,607,570.17</b>	<b>57,574,773.81</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,677,877.28</b>	<b>2,925,437.61</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	320,849.10	2,925,437.61
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,357,028.18	0
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИИТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>1,263,929,692.89</b>	<b>54,649,336.20</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,271,431,489.68</b>	<b>1,189,987,889.09</b>	<b>14,520,691.26</b>	<b>4,475,940,070.03</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,271,431,489.68</b>	<b>1,189,987,889.09</b>	<b>14,520,691.26</b>	<b>4,475,940,070.03</b>
Тайлант үеийн үр дүн			1,263,929,692.89	1,263,929,692.89
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,271,431,489.68</b>	<b>1,189,987,889.09</b>	<b>1,278,450,384.15</b>	<b>5,739,869,762.92</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			1,200,365.60	1,200,365.60
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,271,431,489.68</b>	<b>1,189,987,889.09</b>	<b>1,279,650,749.75</b>	<b>5,741,070,128.52</b>
Тайлант үеийн үр дүн	0	0	54,649,336.20	54,649,336.20
<b>2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>3,271,431,489.68</b>	<b>1,189,987,889.09</b>	<b>1,334,300,085.95</b>	<b>5,795,719,464.72</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>39,925,923,268.60</b>	<b>793,951,796,961.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>13,570,848.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		<b>13,570,848.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>		<b>13,570,848.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		13,570,848.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>39,925,923,268.60</b>	<b>793,938,226,113.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>27,358,895,088.60</b>	<b>29,640,903,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	27,358,895,088.60	29,640,903,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>12,567,028,180.00</b>	<b>764,297,322,213.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,567,028,180.00	764,297,322,213.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>39,775,934,088.60</b>	<b>793,831,934,251.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>39,775,934,088.60</b>	<b>793,831,934,251.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,333,980,849.14</b>	<b>4,577,766,809.72</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,881,582,999.01</b>	<b>1,928,832,937.39</b>
210101	Үндсэн цалин	1,278,849,299.36	1,281,673,478.79
210102	Нэмэгдэл	548,267,699.65	582,598,621.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,466,000.00	64,560,837.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>264,034,062.47</b>	<b>255,089,667.33</b>
210201	Тэтгэврийн даатгал	177,534,364.43	177,632,567.42
210202	Тэтгэмжийн даатгал	21,624,899.45	19,573,877.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,299,999.20	15,531,420.99
210204	Ажилгүйдлийн даатгал	4,324,999.48	3,850,163.79
210205	Эрүүл мэндийн даатгал	43,249,799.91	38,501,637.98
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>74,744,572.21</b>	<b>81,106,858.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	51,136,600.00	60,620,373.00
210302	Түлш, халаалт	18,205,972.21	16,736,804.00
210303	Цэвэр, бохир ус	5,402,000.00	3,749,681.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>75,200,802.45</b>	<b>60,317,025.00</b>
210401	Бичиг хэрэг	11,990,100.00	8,920,300.00
210402	Тээвэр, шатахуун	10,852,000.00	7,840,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,793,031.45	27,666,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,050,000.00	122,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,515,671.00	15,767,075.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>1,429,539.00</b>	<b>351,768.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,429,539.00	351,768.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,786,650.00</b>	<b>27,295,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	25,050,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0	119,900.00
210604	Урсгал засвар	2,786,650.00	2,125,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,313,300.00</b>	<b>1,410,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,313,300.00	1,410,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>30,888,924.00</b>	<b>2,223,363,354.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	2,198,655,350.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	3,043,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,689,246.00	753,886.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,981,700.00	19,121,800.00
210807	Газрын төлбөр	1,828,478.00	526,488.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,389,500.00	1,262,000.00



<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>37,060,986,362.00</b>	<b>788,921,080,742.69</b>
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>24,420,788,000.00</b>	<b>24,511,054,700.00</b>
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	24,420,788,000.00	24,511,054,700.00
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	<b>12,640,198,362.00</b>	<b>764,410,026,042.69</b>
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	12,640,198,362.00	764,410,026,042.69
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>380,966,877.46</b>	<b>333,086,698.59</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>3,495,036.00</b>	<b>1,694,240.00</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	3,495,036.00	1,694,240.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>63,912,745.60</b>	<b>40,038,786.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,985,720.00	22,638,786.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	17,400,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,927,025.60	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>313,559,095.86</b>	<b>289,674,090.59</b>
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0	289,556,090.59
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	313,559,095.86	118,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>1,679,582.00</b>
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	-	1,679,582.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>149,989,180.00</b>	<b>119,862,710.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>149,989,180.00</b>	<b>119,862,710.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>149,989,180.00</b>	<b>119,862,710.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>149,989,180.00</b>	<b>119,862,710.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	149,989,180.00	119,862,710.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-149,989,180.00</b>	<b>-119,862,710.00</b>
<b>25</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-</b>	<b>-</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>29,640,903,900.00</b>	<b>29,364,800,657.41</b>	<b>276,103,242.59</b>	<b>99.1</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>29,640,903,900.00</b>	<b>29,364,800,657.41</b>	<b>276,103,242.59</b>	<b>99.1</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,938,676,200.00</b>	<b>4,697,629,519.72</b>	<b>241,046,680.28</b>	<b>95.1</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,129,674,200.00	1,928,832,937.39	200,841,262.61	90.6
Үндсэн цалин	1,383,109,400.00	1,281,673,478.79	101,435,921.21	92.7
Нэмэгдэл	666,904,500.00	582,598,621.40	84,305,878.60	87.4
Унаа хоолны хөнгөлөлт	79,660,300.00	64,560,837.20	15,099,462.80	81.0
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>291,936,300.00</b>	<b>255,089,667.33</b>	<b>36,846,632.67</b>	<b>87.4</b>
Тэтгэврийн даатгал	205,436,700.00	177,632,567.42	27,804,132.58	86.5
Тэтгэмжийн даатгал	21,624,900.00	19,573,877.15	2,051,022.85	90.5
ҮОМШӨ-ний даатгал	17,299,900.00	15,531,420.99	1,768,479.01	89.8

Эрчим хүчний яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Ажилгүйдлийн даатгал	4,325,000.00	3,850,163.79	474,836.21	89.0
Эрүүл мэндийн даатгал	43,249,800.00	38,501,637.98	4,748,162.02	89.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>81,845,200.00</b>	<b>81,106,858.00</b>	<b>738,342.00</b>	<b>99.1</b>
Гэрэл, цахилгаан	61,258,700.00	60,620,373.00	638,327.00	99.0
Түлш, халаалт	16,836,800.00	16,736,804.00	99,996.00	99.4
Цэвэр, бохир ус	3,749,700.00	3,749,681.00	19.00	100.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>61,107,200.00</b>	<b>60,317,025.00</b>	<b>790,175.00</b>	<b>98.7</b>
Бичиг хэрэг	8,920,300.00	8,920,300.00	-	100.0
Тээвэр, шатахуун	7,840,600.00	7,840,600.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,666,800.00	27,666,800.00	-	100.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	911,700.00	122,250.00	789,450.00	13.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,767,800.00	15,767,075.00	725.00	100.0
<b>Норматив зардал</b>	<b>576,900.00</b>	<b>351,768.00</b>	<b>225,132.00</b>	<b>61.0</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	576,900.00	351,768.00	225,132.00	61.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>147,724,800.00</b>	<b>147,157,910.00</b>	<b>566,890.00</b>	<b>99.6</b>
Багаж, техник, хэрэгсэл	145,000,000.00	144,912,710.00	87,290.00	99.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	495,400.00	119,900.00	375,500.00	24.2
Урсгал засвар	2,229,400.00	2,125,300.00	104,100.00	95.3
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,410,000.00</b>	<b>1,410,000.00</b>	-	<b>100.0</b>
Дотоод албан томилолт	1,410,000.00	1,410,000.00	-	100.0
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,224,401,600.00</b>	<b>2,223,363,354.00</b>	<b>1,038,246.00</b>	<b>100.0</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,198,655,400.00	2,198,655,350.00	50.00	100.0
Даатгалын үйлчилгээ	3,950,000.00	3,043,830.00	906,170.00	77.1
Тээврийн хэрэгслийн татвар	762,400.00	753,886.00	8,514.00	98.9
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,121,800.00	19,121,800.00	-	100.0
Газрын төлбөр	650,000.00	526,488.00	123,512.00	81.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,262,000.00	1,262,000.00	-	100.0
<b>ТАТААС</b>	<b>24,657,225,100.00</b>	<b>24,625,438,111.69</b>	<b>31,786,988.31</b>	<b>99.9</b>
<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>24,511,054,700.00</b>	<b>24,511,054,700.00</b>	-	<b>100.0</b>
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	24,511,054,700.00	24,511,054,700.00	-	100.0
<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	<b>146,170,400.00</b>	<b>114,383,411.69</b>	<b>31,786,988.31</b>	<b>78.3</b>
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	146,170,400.00	114,383,411.69	31,786,988.31	78.3
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>45,002,600.00</b>	<b>41,733,026.00</b>	<b>3,269,574.00</b>	<b>92.7</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>4,400,000.00</b>	<b>1,694,240.00</b>	<b>2,705,760.00</b>	<b>38.5</b>
Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,400,000.00	1,694,240.00	2,705,760.00	38.5
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>40,602,600.00</b>	<b>40,038,786.00</b>	<b>563,814.00</b>	<b>98.6</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,202,600.00	22,638,786.00	563,814.00	97.6
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,400,000.00	17,400,000.00	-	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>29,640,903,900.00</b>	<b>29,364,800,657.41</b>	<b>276,103,242.59</b>	<b>99.1</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>29,640,903,900.00</b>	<b>29,351,229,809.41</b>	<b>289,674,090.59</b>	<b>99.0</b>
Улсын төсвөөс санхүүжих	29,640,903,900.00	29,351,229,809.41	289,674,090.59	99.0
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	13,570,848.00	<b>(13,452,848.00)</b>	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	13,570,848.00	<b>(13,452,848.00)</b>	-
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>95</b>	<b>89</b>	6.00	93.7
Удирдах ажилтан	13	12	1.00	92.3
Гүйцэтгэх ажилтан	68	63	5.00	92.6
Үйлчлэх ажилтан	14	14	0.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>764,295,642,631.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>764,295,642,631.00</b>
<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>		<b>764,295,642,631.00</b>
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас		764,295,642,631.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>764,295,642,631.00</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		764,295,642,631.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		764,295,642,631.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрчим хүчний яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар ирүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-наас 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хооронд ахлах аудитор Л.Нямтөмөр, аудитор С.Бат-Эрдэнэ нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлэв.

Эрчим хүчний яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн в/291 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрчим хүчний яамны эрхэм зорилго нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн өсөлтийг хангахуйц эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, хүний эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах болон үйлдвэрлэл, үйлчилгээний найдвартай, тогтвортой нөхцөлийг хангахад үйл ажиллагааг чиглүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Эрчим хүчний яамны хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газраас тайлант онд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрчим хүчний яамны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 39,966,895.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 399,669.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг аудитын явцад дахин хянахад гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрчим хүчний яамны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 54,219.0 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	755.6	13,462.8	12,707.2
Бараа материал	37,172.7	77,092.7	39,920.0
Үндсэн хөрөнгө	5,703,690.2	5,705,164.0	1,473.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,741,618.5</b>	<b>5,795,837.5</b>	<b>54,219.0</b>
Өр төлбөр	1,748.7	118.0	(1,630.7)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,739,869.8	5,795,719.5	55,849.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>5,741,618.5</b>	<b>5,795,837.5</b>	<b>54,219.0</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 12,707.2 мянган төгрөгөөр өссөн нь ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон ажилтанд олгосон нөхөн төлбөрийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаас нэхэмжилсэн авлагын үлдэгдэл дүнгээр өссөн;
- Бараа материал дансны үлдэгдэл 39,920.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 25,050.0 мянган төгрөгийн программ хангамжийн лиценз худалдан авсан болон үндсэн хөрөнгийн данснаас 18,547.7 мянган төгрөгийн бараа шинжтэй бараа материалыг шилжүүлж бүртгэснээс шалтгаалсан;
- Үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 119,862.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ТӨБЗГ-ын зөвшөөрлөөр Таван толгой дулааны станц ТӨХК-аас 225,000.0 мянган төгрөгийн суудлын автомашин, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-аас 18,529.4 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг балансаас баланст шилжүүлэн авсан дүнгээр нэмэгдэж, 88,350.0 мянган төгрөгийн автотээврийн хэрэгслийг балансаас баланст шилжүүлсэн, 18,547.7 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд шилжүүлсэн, акталж данснаас хассан 59,885.8 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан;

- Өр төлбөр дансны үлдэгдэл 118.0 мянган төгрөг байгаа нь жилийн эцэст нэр данс зөрүү буцсан гүйлгээнээс үүссэн өглөг бүртгэгдсэн;
- Засгийн газрын хувь оролцооны үлдэгдэл 55,849.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан;

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 57,662,352.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 57,662,352.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 27,973,288.5 мянган төгрөгөөр бууруулж, 29,689,063.6 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төрийн өмчит болон хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас санхүүжилтийн зардлыг бууруулж хянасан нь голлон нөлөөлсөн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны тодотгосон төсвөөр төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 29,640,903.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 29,640,903.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 29,364,800.6 мянган төгрөгийг зарцуулж 276,103.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 29,364,800.6 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаа арга хэмжээний зардал 241,046.8 мянга, агаарын чанарыг сайжруулахад олгох татаас 31,787.0 мянга, олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж 2,705.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70906	Эрчим хүч, уул уурхайн бодлого	29,640,903.9	29,364,800.6	276,103.3	99.1
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,740,020.8	2,498,974.0	241,046.8	91.2
1.2	80401	Цахилгаан дамжуулах системийн алдагдал	17,700,000.0	17,700,000.0	0.0	100.0
1.3	80402	Дулааны станцын алдагдал	5,311,054.7	5,311,054.7	0.0	100.0
1.4	80410	Агаарын чанарыг сайжруулахад олгох татаас	146,170.4	114,383.4	31,787.0	78.3
1.5	80411	Дизелийн станцын алдагдлын татаас	1,500,000.0	1,500,000.0	0.0	100.0
1.6	80417	Эгийн голын усан цахилгаан станц	2,198,655.4	2,198,655.4	0.0	100.0
1.7	80509	ОУ-ын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	4,400.0	1,694.2	2,705.8	38.5
1.8	80704	Ахмад дайчин, алдар цолтой ахмадын нэмэгдэл	17,400.0	17,400.0	0.0	100.0
1.9	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	23,202.6	22,638.9	563.7	97.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн



бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас нийт 764,297,322.2 мянган төгрөгийн орлого хүлээн авсан нь Засгийн газрын 2017 оны “Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам” батлах тухай 199 дүгээр тогтоолын дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 18,887,579.2 мянган төгрөгийн, 2020 оны “Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дүгээр тогтоолын дагуу Сангийн яамнаас 745,409,743.0 мянган төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.

Үүнээс Гэр хорооллын айл өрхийн цахилгаан хангамжийн техникийн боломжийг бүрдүүлэхэд болон шөнийн тарифын хөнгөлөлтийн санхүүжилтэд 18,885,900.0 мянган төгрөгийг, айл өрхийн болон зарим аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төрөөс хариуцан төлөх арга хэмжээнд 745,409,743.0 мянган төгрөгийг зарцуулж, 1,679.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Эрчим хүчний яам нь тайлант онд 72 зорилтын хүрээнд 197 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлтийг 96.1 хувьтай дүгнэсэн байна. Хөтөлбөр, арга хэмжээнд төлөвлөсөн зардлын гүйцэтгэл 99.1 хувийн биелэлттэй, 0.9 хувь буюу 276,103.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Засгийн газрын 2020 оны “Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дүгээр тогтоолын дагуу 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хорооны тооцоо нийлсэн актын гүйцэтгэлээс үзэхэд төрөөс хариуцах төлбөрийн гүйцэтгэл 868,497,917.2 мянган төгрөг байгаагаас тайлант онд Сангийн яамнаас 745,409,743.0 мянган төгрөгийг санхүүжүүлж, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагуудад хуваарилсан ба үлдэгдэл төлбөрийг 2022 оны 1, 2 дугаар сард бүрэн санхүүжүүлсэн байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) цахим хуудсанд Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын 3 дугаар улирлын мэдээлэл, аудитын тайлан, дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн, 10,065.2 мянган төгрөгийн 1 орлогын гүйлгээ, 7 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авсан 123,037.2 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн

дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д " Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-т " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулах, илэрсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 433,711.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад залрууллаа.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 613,171.4 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 17,271.2 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснөөс 3 албан шаардлага бүрэн хэрэгжиж, 2 албан шаардлага бүрэн хэрэгжүүлээгүй, 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	5	613,171.4	3	473,631.2	2	139,540.2	28.0
Зөвлөмж	2	17,271.2	2	17,271.2	0	-	0
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>630,442.6</b>	<b>5</b>	<b>490,902.4</b>	<b>2</b>	<b>139,540.2</b>	<b>28.0</b>

Төсвийн хууль тогтоомж болон холбогдох заавар журмыг зөрчиж, төсвийн эдийн засгийн ангиллыг бүлэг хооронд шилжүүлсэн зөрчлийг арилгах, Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Гэр хорооллын айл өрхийн цахилгаан хангамжийн техникийн боломжийг бүрдүүлэх 7 багц ажлын гэрээний гүйцэтгэл, барьцааны дансанд төвлөрүүлсэн 84,142.1 мянган төгрөгийн зарцуулалтыг;

Засгийн газрын 2020 оны "Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" 211 дүгээр тогтоолын дагуу 2021 онд айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөрийг төрөөс хариуцан төлөх арга хэмжээний санхүүжилтийн хуваарилалт зэргийг дараагийн шатны аудитаар тулган баталгаажуулна.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 175,997.8 мянган төгрөгийн 14 алдаа зөрчил илэрснээс, 141,425.9 мянган төгрөгийн 7 алдааг залруулж, 600.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 31,766.6 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 2,205.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 7 алдаа, зөрчлийн дүн 34,571.9 мянган төгрөг нь тогтоосон 399,669.0 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Тайлант хугацаанд акталсан 906.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаар бүртгэж, данс бүртгэлд буруу тусгасан;
- Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардлыг 99,567.6 мянган төгрөгөөр дутуу тооцоолж, санхүүгийн үр дүнгийн тайланд зардал дутуу илэрхийлсэн;
- Тайланд хугацаанд худалдан авсан 25,050.0 мянган төгрөгийн өртөг бүхий нэг жилийн ашиглах эрхтэй оффисын программын лицензийг программ хангамжийн дансанд буруу ангилж бүртгэсэн;
- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 533.0 мянган төгрөгийн хөрөнгийг ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн акталж, данс бүртгэлээс хассан;
- Тайлант хугацааны 13,570.8 мянган төгрөгийн орлогын гүйлгээний эдийн дансны засгийн ангиллыг буруу бүртгэж, тайлагнасан;
- Санхүүгийн үр дүнгийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн зардлыг 118.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Нэмэлт санхүүжилтийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн зардлыг 1,679.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;

##### 4.2 Төлбөрийн акт

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн Б/02 дугаар тушаалаар ажлаас түр чөлөөлөгдсөн ажилтанд 1 дүгээр сард 600.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалин олгосоныг суутгаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урьдчилгаа цалин илүү олгосон 600.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

##### 4.3 Албан шаардлага

Ажиллагсадтай холбоотой өмнөх оноос шилжин ирсэн болон тайланд онд шинээр үүссэн 616.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5-д “ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, он дамжсан авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, авлагын үлдэгдлийг барагдуулах, албан шаардлага хүргүүлэв.

Ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 1 ажилтанд олгосон нөхөн төлбөрийн 12,846.4 мянган төгрөгийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнуудаар бүрэн төлүүлж төрийг хохиролгүй болгоогүйгээс жилийн эцсийн

санхүүгийн тайланд авлагын үлдэгдлээр тайлагнасан байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг авах, албан шаардлага хүргүүлэв.

Сангийн яамнаас Төсвийн зохицуулалт хийх зөвшөөрөл авалгүйгээр ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас цалингийн зардалд 2,218.2 мянга, мэдээллийн технологийн зардлаас эд хогшил урсгал засварын зардалд 1,239.0 мянга, багаж, техник, хэрэгслийн зардалд 846.9 мянган төгрөгийг тус тус гүйлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.1.6-д "... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль тогтоомж болон холбогдох журам, зааврыг зөрчиж, төсвийн эдийн засгийн ангиллыг бүлэг хооронд шилжүүлсэн зөрчлийг арилгах, албан шаардлага хүргүүлэв.

Улсын Онцгой Комиссоос хүргүүлсэн шуурхай штабын бүрэлдэхүүнд ажилласан албан хаагчдад урамшуулал олгох тухай 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 1431 дугаар албан бичгийг үндэслэн Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын "Тусламж олгох" 2021 оны Б/142 дугаар тушаалаар Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын эрсдэлтэй нөхцөл байдлын үед тусгай горимоор ажилласан гэх нэр бүхий 15 албан хаагчдад 13,999.7 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллаагүй зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, албан шаардлага хүргүүлэв.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

###### **1.1 Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн дансанд ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 320 нэр төрлийн 501,860.3 мянган төгрөгийн дансны үнэ бүхий үндсэн хөрөнгө бүртгэлтэй хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлэх саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчит эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1 дэх заалт, УСНББОУС17-ийн 44-д "Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа, бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадах үндсэн

хөрөнгийн зүйлийг түүний дахин үнэлсэн дүнгээр бүртгэж тусгана” гэж заасантай нийцэхгүй байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:**

Элэгдлээ бүрэн нөхөж үлдэх өртөггүй болсон ч цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх, харин ашиглах боломжгүй хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт хүргүүлж данс бүртгэлээс хасах.

**2. Зардлын данстай холбоотой асуудал**

**2.1 Илрүүлэлт:**

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны Б/287 дугаар тушаалаар тус яамны 2020 оны шилдэг ажилтнаар шалгарсан 5 ажилтныг үндсэн цалингийн 30 хувиар буюу нийт 2,205.3 мянган төгрөгөөр шагнаж урамшуулахаар шийдвэрлэсэн ч 2021 оны төсвөөс зардлыг санхүүжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:**

Тайлант оны батлагдсан төсвөөс зөвхөн тухайн жилийн хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар</b>														
1	Эрчим хүчний яам	АХГ-2022/384/НА-СТА-ТШЗ	Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн Б/02 дугаар тушаалаар ажлаас түр чөлөөлөгдсөн ажилтанд 1 дүгээр сард 600.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалин олгосоныг суутгаагүй.	Урьдчилгаа цалин илүү олгосон 600.0 мянган төгрөгийг холбогдох этгээдээр нөхөн төлүүлэх.	1	600.0			1	600.0				
2	Эрчим хүчний яам	АХГ-2022/384/НА-СТА-ТШЗ	Ажиллагсадтай холбоотой өмнөх оноос шилжин ирсэн болон тайланд онд шинээр үүссэн 616.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй.	Төсвийг зохистой удирдаж, он дамжсан авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, авлагын үлдэгдлийг барагдуулах.	1	616.4					1	616.4		
3	Эрчим хүчний яам	АХГ-2022/384/НА-СТА-ТШЗ	Ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 1 ажилтанд олгосон нөхөн төлбөрийн 12,846.4 мянган төгрөгийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнуудаар бүрэн төлүүлж төрийг хохиролгүй болгоогүйгээс жилийн эцсийн санхүүгийн тайланд авлагын үлдэгдлээр тайлагнасан.	Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг авах.	1	12,846.4					1	12,846.4		
4	Эрчим хүчний яам	АХГ-2022/384/НА-СТА-ТШЗ	Сангийн яамнаас Төсвийн зохицуулалт хийх зөвшөөрөл авалгүйгээр ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас цалингийн зардалд 2,218.2 мянга, мэдээллийн технологийн зардлаас эд хогшил урсгал засварын зардалд 1,239.0 мянга, багаж, техник, хэрэгслийн зардалд 846.9 мянган төгрөгийг тус тус гүйлгэн зарцуулсан байна.	Төсвийн тухай хууль тогтоомж болон холбогдох журам, зааврыг зөрчиж, Төсвийн эдийн засгийн ангиллыг бүлэг хооронд шилжүүлсэн зөрчлийг арилгах	1	4,304.1					1	4,304.1		





			программ хангамжийн дансанд буруу ангилж бүртгэсэн.														
11	Эрчим хүчний яам	АХГ-2022/384/НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 533.0 мянган төгрөгийн хөрөнгийг ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн акталж, данс бүртгэлээс хассан.	Залруулах	1	533.0	1	533.0									
12	Эрчим хүчний яам	АХГ-2022/384/НА-СТА-ТШЗ	Тайлант хугацааны 13,570.8 мянган төгрөгийн орлогын гүйлгээний эдийн дансны засгийн ангиллыг буруу бүртгэж, тайлагнасан.	Залруулах	1	13,570.8	1	13,570.8									
13	Эрчим хүчний яам	АХГ-2022/384/НА-СТА-ТШЗ	Санхүүгийн үр дүнгийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн зардлыг 118.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	Залруулах	1	118.0	1	118.0									
14	Эрчим хүчний яам	АХГ-2022/384/НА-СТА-ТШЗ	Нэмэлт санхүүжилтийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн зардлыг 1,679.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	Залруулах	1	1,679.6	1	1,679.6									
<b>Дүн</b>					<b>14</b>	<b>175,997.8</b>	<b>7</b>	<b>141,425.9</b>	<b>1</b>	<b>600.0</b>	<b>4.00</b>	<b>31,766.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>2,205.3</b>	
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>																	
1	Эрчим хүчний яам	АХГ-2022/384/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад shilendans.gov.mn цахим хуудсанд Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын 3-р улирлын мэдээлэл, аудитын тайлан, дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 орлогын гүйлгээний 10,065.2 мянган төгрөгийн, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авсан 123,037.2 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг мэдээлээгүй.	Шилэн дансны тухай хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулах, илэрсэн зөрчлийг арилгах	1	133,102.4					1	133,102.4					
<b>Дүн</b>					<b>1</b>	<b>133,102.4</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>133,102.4</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>-</b>	
<b>Нийт дүн</b>					<b>15</b>	<b>309,100.2</b>	<b>7.0</b>	<b>141,425.9</b>	<b>1.0</b>	<b>600.0</b>	<b>5.00</b>	<b>164,869.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>2,205.3</b>	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 04/А0170065  
АХГ-2022/384/НА-СТА-ТМЗ  
Төлбөрийн акт тогтоох тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу гүйцэтгэсэн Эрчим хүчний яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн Б/02 дугаар тушаалаар ажлаас түр чөлөөлөгдсөн Төрийн захиргаа удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдоржид 01 дүгээр сард 600,000 төгрөгийн урьдчилгаа цалин олгосныг суутгаж аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даван гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Урьдчилгаа цалин илүү олгосон 600,000 төгрөгийг холбогдох албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Жанарбаатар нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ХОСЖАРГАЛ

С.БАТ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Akt\2022\0225 Auditin 2 Gazar-6.Docx

001090022



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 07/А0170065

Улаанбаатар хот

АХГ-2022/384/НА-СТА-ТЦЗ  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу гүйцэтгэсэн Эрчим хүчний яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын 3 дугаар улирлын мэдээлэл, аудитын тайлан, дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн, 10,065,224.00 төгрөгийн 1 орлогын гүйлгээ, 7 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авсан 123,037,221.00 төгрөгийн бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.3 тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, нягтлан бодогч Л.Оюундэлгэр нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ  
С.БАТ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_N\hereg\Albin Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-14.Docx

0001080067



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 08/А0170065

Улаанбаатар хот

АХГ-2020/384/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу гүйцэтгэсэн Эрчим хүчний яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын Онцгой Комиссоос хүргүүлсэн шуурхай штабын бүрэлдэхүүнд ажилласан албан хаагчдад урамшуулал олгох тухай 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 1431 дугаар албан бичгийг үндэслэн Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын "Тусламж олгох" 2021 оны Б/142 дугаар тушаалаар Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын эрсдэлтэй нөхцөл байдлын үед тусгай горимоор ажилласан гэх нэр бүхий 15 албан хаагчдад 13,999,700.00 төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийг зарчмыг хэрэгжүүлэх: 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Жанарбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

*(Handwritten signatures)*

Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ  
С.БАТ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9919120386

\\10.10.10.20\Bichig\_Kherem\Alban\_Shaardlaga\2022\0225\_Auditin\_2\_Gazar-15.Docx

0001080065





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 03/А0170065  
АХГ-2022/384/МА-СТА-ТЦЗ  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу гүйцэтгэсэн Эрчим хүчний яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажиллагсадтай холбоотой өмнөх оноос шилжин ирсэн болон тайлант онд шинээр үүссэн 616,370.00 төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Авлага барагдуулж, зөрчлийг арилган, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, Нягтлан бодогч Л.Оюундэлгэр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ХОСЖАРГАЛ

С.БАТ-ЭРДЭНЭ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10.20\Btchig\_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-17.Docx

001080074





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 10/А070065  
АХГ-2022/384/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу гүйцэтгэсэн Эрчим хүчний яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 1 ажилтанд олгосон нөхөн төлбөрийн 12,846,405.00 төгрөгийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар бүрэн төлүүлж, төрийг хохиролгүй болгоогүйгээс жилийн эцсийн санхүүгийн тайланд авлагын үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагын үлдэгдэлд тайлагнасан 12,846,405 төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, төрд учирсан хохирлыг барагдуулах, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Жанарбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ  
С.БАТ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9006109  
90191 MO.10.10.20/Bichig\_Kherэг/Alban\_Shaardlaga/2022/0225/Auditin\_2\_Gazar-16.Docx

001080070



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 11/АД/170065

Улаанбаатар хот

АХГ- 2022/384/НА-СТА-ТЧЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу гүйцэтгэсэн Эрчим хүчний яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сангийн яамнаас төсвийн зохицуулалт хийх зөвшөөрөл авалгүйгээр ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас цалингийн зардалд 2,218,160.00 төгрөг, мэдээллийн технологийн зардлаас эд хогшил, урсгал засварын зардалд 1,239,000.00 төгрөг, багаж, техник, хэрэгслийн зардалд 846,900.00 төгрөг, нийт 4,304,060.00 төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.1.6 "... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хууль тогтоомж болон холбогдох журам, зааврыг зөрчиж, Төсвийн эдийн засгийн ангиллыг бүлэг хооронд шилжүүлсэн зөрчлийг арилгаж биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, нягтлан бодогч Л.Оюундэлгэр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ  
С.БАТ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264250

9006109  
9006109  
\\10.10.10.20\Bichig\_Kherem\Alban\_Shaardlaga\2022\0225\_Auditin\_2\_Gazar-18.Docx

001080076

